



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар Б1128

Улаанбаатар хот

**Эрчим хүчний хэмжлийн нэгдмэл байдлыг
хангуулах сэдэвт сургалт зохион байгуулах тухай**

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.12 дахь заалт, Захиргаа, ҮЭ-ийн хороотой байгуулсан “2017-2018 оны Хамтын гэрээ”-ний 3.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хэмжилзүйчдийн холбоо” ТББ-аас зохион байгуулах “Эрчим хүчний хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах нь” сэдэвт сургалтад тус компанийн хавсралтад нэр заасан 10 ажилтныг 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ажлын 1 хоног хамруулсугай.

2. Сургалтад хамрагдах ажилтнуудыг сургах нөхцөлөөр хангах түүнийг зохион байгуулан ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

3. Дээрх сургалтын төлбөр болох 600,000 /Зургаан зуун мянга/ төгрөгийг сургалтын зардлаас тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.2019

300000908